



**ДУНДГОВ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 03 едөр

Дугаар A/11

Мандалговь

**Короновирусын халдварын болзошгүй
эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр
авах арга хэмжээний тухай**

Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, 15.1.6, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтууд, Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолын 7, 10, 11, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 01 дүгээр албан даалгаврын 1 болон 3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2020 оны А/01 дүгээр албан даалгаврын 3 дахь хэсэг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны А/13 дугаар тушаалын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ коронавирусийн халдварт болон томуу, томуу төст өвчний үед болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж, улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан байгууллагын 0-5 хүртэлх насны хүүхэдтэй албан хаагчдыг 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл хугацаанд ажлын 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. 0-18 хүртэлх насны хүүхэдтэй албан хаагчдыг 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл хугацаанд өдөр бүр 09:00-12:00, 14:00-17:00 цаг хүртэл богиносгосон цагаар ажиллуулсугай.

3. Үйл ажиллагааны төлөвлөгөөг 1 дүгээр, ажлын хэсгийг бүрэлдэхүүнийг 2 дугаар, төсвийг 3 дугаар, байгууллагын албан хаагчдын хүүхдийн насны судалгааг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

4. Хавсралтын дагуу нийт албан хаагчдын цалинтай чөлөө болон богиносгосон цагийг үндсэн цагаар ажилласанд тооцон цалинжуулах, үйл ажиллагаатай холбоотой зардал шийдвэрлэхийг нягтлан бодогч /С.Чинбат/-д зөвшөөрсүгэй.

5. Короновирусын халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг чанартай зохион байгуулан, өөрийн хүүхэд, гэр булийн хараа хяналтыг сайжруулан, аюулгүй байдлыг ханган ажиллаж, 7 хоног бүрийн шуурхайд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Хүүхэд хамгааллын мэргэжилтэн /Б.Цэцэг/, гишүүд, нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ



4811900 ?